



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/132

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.б, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 07 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүрд сумын нутаг дэвсгэр дэх “Тарнын гүүрний хяналтын цэг”-т ажиллах албан хаагчдын үйл ажиллагаа, илүү цагийн урамшуулалд шаардагдах зардал 6,530,400 (зургаан сая таван зуун гучин мянга дөрвөн зуу) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

2.Хяналтын постонд ажиллах албан хаагчдын ажил үүргийн дагуу халдвар хамгааллын дэглэмийг хангуулах, зохион байгуулалтын арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100292

Аймгийн Засаг даргын 2021 оны...
 дугаар сарын ...-ны өдрийн ... дүгээр
 захирамжийн хавсралт



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БҮРД СУМЫН ТАРНЫ ПОСТЫН
 ЗАРДЛЫН НЭМЭЛТ ТООЦОО

№	Шаардагдах хэрэгсэл	Тоо хэмжээ /ширхэг/	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Нийт үнэ /мян.төг/
1. Үйл ажиллагааны зардал				
1	Хоол	11 хоног /11хүн/	15000	1815000
2	Нүүрс шуудай	30	3500	105000
	Мод шуудай	40	5000	200000
3	Шатахууны зардал ээлж солилцох	100л	1500	150000
4	Албан хаагчдын машинд бензин	1 хоногт-30л 11хоногт-330л	1500	495000
5	Гарын цаасан салетка	5ш	6500	32500
6	цэвэрлэгээний алчуур	3ш	8000	24000
7	Хогийн уут	3 боодол	5500	16500
8	3 өнгө алчуур	3 хос	5500	16500
9	Гарын саван	2 ш	2000	4000
10	Белизна	2 ш	3350	6700
11	Кофе	1 уут	14500	14500
12	Цэвэр ус (баллонтой)	5	3500	17500
13	Липтон цай	1 хайрцаг	3200	3200
				2900400
2. Илүү цагийн урамшуулал				
14	Албан хаагчдын илүү цагийн урамшуулал	11*11=121	30000	3630000
				3630000
Нийт дүн				6530400